

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН
2017 ОНЫ 3-Р УЛИРАЛД ХЭРЭГЖҮҮЛСЭН
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН**

2017.09.25.

Арвайхээр сум

Тус цагдаагийн газрын алба хаагчид нь Цагдаагийн Ерөнхий Газраас 2017 онд дэвшүүлсэн зорилт, Цагдаагийн Ерөнхий Газрын даргын тушаалаар 2009 онд баталсан "Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт", "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам", холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагатай түншлэлийн холбоо тогтоож, хамтран ажиллах, алба хаагчдын сахилга ёс зүй, ажлын хариуцлага, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, ая тохитой орчинд ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар

Энэ хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тогтоол, эрх зүйн бичиг баримт, Хууль зүй дотоод хэргийн сайд, ЦЕГ-ын даргын "Цагдаагийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн" дээр өгсөн үүрэг ажлын чиглэл, дэд дарга нарын өгсөн үүрэг даалгавар, тушаал, шийдвэрийг бие бүрэлдэхүүнд танилцуулж, үр дүнгийн гэрээнд тусгуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Цагдаагийн газраас "2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө", "Сургалтын төлөвлөгөө", "Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө", "Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө", "Дотоод аюулгүй байдлыг хангах ажлын төлөвлөгөө", "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах удирдамж төлөвлөгөө", "Урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө", зэрэг баримт бичгүүдийг батлан гаргаж хэлтэс тасаг, хэсгийн төлөөлөгч нарт хүргүүлсэн. Цагдаагийн газрын хэлтэс, тасаг, хэсгийн төлөвлөгөөнд алба хаагчдаас шинэ санал санаачилга гаргаж ажиллах талаар тусгаж хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. 10 дугаар сарын 13-14 ний өдрүүдэд Хууль зүй яамны ажлын хэсэг тус цагдаагийн газарт хүрэлцэн ирж аймгийн Засаг даргын Хууль зүйн сайдтай 2017 онд байгуулсан гэрээний хэрэгжилтийн явц байдлыг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөв. Аймгийн Аудитын газраас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын явц байдалд хөндлөнгийн аудит хийж үнэлгээ өгөв.

Хоёр. Алба хаагч ажилтны нийгмийн баталгааг хангах чиглэлээр

Тус цагдаагийн газрын алба хаагчдын санаачилгаар Цагдаагийн албаны тухай хуулийн 17-ийн 1-д заасан алба хаагчдын бие бялдрын стандартын түвшинг хангах, мэргэжлийн бэлтгэл албаны болон давтан сургалт зохион байгуулж байх "Сургалтын төв"-ийг барихаар 2017 оны 07 дугаар сарын 05-нд Тарагт сумын Засаг даргад хүсэлт тавин Арвайхээр хотоос зүүн тийш хуучин "Цагаан хаалга"-ны зүүн хойд талд 2 га газрын асуудлыг шийдвэрлүүлж, зээлийн эх үүсвэрээр барилга байгууламжийн ажлыг зураг төсвийн дагуу эхлүүлээд байна. Өнөөдрийн байдлаар тасгууд хариуцан тоосгон ханатай сүүлийн үеийн өндөр чанартай

материалаар баригдсан 5*5 хэмжээтэй тус бүр нь 7.5 сая төгрөгний өртөг бүхий 5 ширхэг амралтын байр, 4.5 сая төгрөгний өртөг бүхий 130 метр цахилгаан шугам дагалдах хэрэгсэл, 4 ширхэг гадна гэрэлтүүлэг, 80 метр чулуун зам тавиад байгаа бөгөөд өөрсдийн нөөц боломжийг ашиглан байгууллагын урсгал зардлаас 2.2 сая төгрөгөөр газар шорооны ажил, 2.4 сая төгрөгний тавилга тоног төхөөрөмж, 2.7 төгрөгний цахилгаан утас дагалдах хэрэгсэл, 1.2 сая төгрөгний бүтээлэг, гудас хөнжил зэрэг эргэлтийн хөрөнгө авч ашиглаж эхлээд байна.

Мөн төмөр хашааны суурийг зураг төсвийн дагуу цэвэр үзэмжтэй бөх бат хийх зорилгоор 3 үе блок давхарлан өрөх шаардлагатай болсон тул иргэдийн дэмжлэгээр блокны машиныг түр хугацаагаар түрээслэн авч алба хаагчдын хүчээр 10 хоногийн хугацаанд 8000 орчим хайрган блок цутгаж, 10 дугаар сарын 23-ны өдөр хашааг чанарын өндөр түвшинд барьж дуусгав. Мөн стандартын шаардлага хангасан бие засах газар, хогийн цэгийг богино хугацаанд чанартай хийж байрлуулав. 2017.10.09-ны өдөр “Баянговь-Ус” ХХК-тай 10 сая төгрөгний гэрээ байгуулан цэвэр усны худгийн өрөмдлөгийн ажлыг эхлүүлэн 2017.10.19-ны өдөр дуусгаж, худгийг хүлээн авсан байна.

Амралтын байруудад шалны халаалт тавьсан бөгөөд 09 дүгээр сарын 20-23 ны хооронд зохион байгуулагдсан тус аймгаас төрөн гарсан Монгол улсын гавьяат цолтон, төв орон нутгийн цагдаагийн газар хэлтсийн даргаар ажиллаж байсан цагдаагийн хурандаа цолтнуудыг гэр бүлийн нь хамт 4 хоног, ЦЕГ-аас зохион байгуулж буй “Бүсчилсэн сургалт”-ын хүрээнд аймгийн иргэд олон нийтэд уран бүтээлээ толилуулж, соён гэгээрүүлэх ажил хийхээр хүрэлцэн ирсэн ЦЕГ-ын “Сүлд” чуулгын уран бүтээлчдийг 2 хоногийн хугацаагаар хүлээн авч байрлуулж, үйлчлүүлэгчдийн талархлыг хүлээсэн бөгөөд төсөв зардал хэмнэсэн үр дүнтэй ажил болсон нь мэдрэгдэж байна. Уг байгууламжийг орон нутгийн өмчид авахуулж, ашиглалтанд оруулсан 5 амралтын байрны зардал 37.5 сая төгрөг, цахилгаан шугам дагалдах хэрэгслийн үнэ 4.5 сая төгрөг, эд зүйл хадгалах агуулах, бие засах газар, цахилгааны дотоод сүлжээний зардал 4.6 сая төгрөг, төмөр хашаа барих зардал 25.0 сая төгрөг /хашаа барих төсөвт зардал 40,9 сая төгрөгнөөс нэн шаардлагатай байгаа нийт 71.6 сая төгрөгийг төсвийн тодотголд тусгаж санхүүжилтийг шийдвэрлүүлэх талаар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга А.Ишдорж, аймгийн Засаг дарга Г.Ганболд нарт 09 дүгээр сарын 07-ны өдөр 47/3282, 47/3283 дугаар албан бичгээр хүсэлт хүргүүлж аймгийн удирдлагууд “Сургалтын төв”-ийн бүтээн байгуулалттай энэ 9 дүгээр сард биечлэн ирж танилцаж ИТХ-ын тогтоолоор хашааны зардал 25 сая төгрөгийг шийдвэрлэж өгсөн болно. Мөн “Сургалтын төв”-ийн бүтээн байгуулалтыг “Бүсчилсэн сургалт”-нд хүрэлцэн ирсэн ЦЕГ-ын дэд дарга цагдаагийн хурандаа М.Лувсандорж, Захиргааны удирдлагын газрын дарга, цагдаагийн хурандаа П.Оростогоо болон бусад удирдах дарга нар биечлэн танилцаж, үнэтэй санал зөвлөмж өгсөн байна.

Цаашид уг сургалтын төвийг “Хангайн бүсийн цагдаагийн газруудын алба хаагчдын сургалтын төв” болгох зорилт тавин 10*12 хэмжээтэй 80 хүний суудалтай сургалтын байр, гүйлтийн зам, биеийн тамирын талбай, орчин үеийн инженерийн шийдэл бүхий зоогийн газар зэрэг бүтээн байгуулалтын ажлыг зураг төсвийн дагуу үргэлжлүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Мөн алба хаагчдын дунд “Сургалтын төв”-ийн амралтын байр барих бүтээлч ажлын уралдаан зохион байгуулж, хамт олноо тэргүүлсэн НХЖХТ-ийн 28 алба хаагч, гэр бүлийн гишүүдийг 647500 төгрөгний зардлаар Бат-Өлзий сумын чиглэлд аялалаар явуулсан бөгөөд хайрган блок цохих, хашааны суурь цутгах, өрлөг хийх, гагнуураар төмөр хашаа гардан хийж буй хэв журмын цагдаа цагдаагийн сургагч ахлагч А.Хишигт, цагдаагийн дэд ахлагч

П.Ганбаатар, цагдаагийн дэд ахлагч С.Чулуунбаатар, слесарь Ө.Батцэнгэл нарыг ЦЕГ-ын шагналаар шагнуулж урамшуулах саналыг хүргүүлж сарын цалинг 1 сар 50 хувиар шагнах тухай ЦЕГ-ын даргын тушаал гарч хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Гурав. “Иргэдэд ойр эрх зүйн үйлчилгээний жил”-ийн төлөвлөгөөний хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил

Монголын Хуульчдын холбооны Өвөрхангай аймаг дахь Салбар байгуулагдсаны 1 жилийн ойг тохиолдуулан “Хуулийн байгууллагуудын нэгдсэн нээлттэй хаалганы өдөрлөг”-ийн арга хэмжээг 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр “Аюуш” баатрын талбайд зохион байгуулагдаж, арга хэмжээнд аймгийн Хууль эрх зүйн хэлтэс, Шүүх, Прокурор газар, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Шүүх шинжилгээний алба, Өмгөөлөгчдийн зөвлөл, Нотариатын салбар, Хүний эрхийн салбар зөвлөл зэрэг хууль хяналтын байгууллагын болон Архивын тасаг, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл, иргэд олон нийт өргөнөөр оролцов. Өдөрлөгт оролцогч байгууллагууд өөрсдийн онцлог чиг үүргийн хүрээнд хууль эрх зүйн зөвлөгөө, мэдээллийг өгч, байгууллагынхаа ажил, үйлчилгээг сурталчлах, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг нь хүлээн авч, шаардлагатай тохиолдолд газар дээр нь шийдвэрлэх чиглэлээр ажиллалаа. Энэхүү арга хэмжээнд Цагдаагийн газраас байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах, мэдээллийн ил тод байдлыг хангах, цагдаагийн мэргэжлийн албадын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор “Амар тайван амьдралын төлөө хамтдаа” уриан дор хамтран зохион байгуулсан.

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран орон нутгийн Арвайхээр телевизтэй хамтран бага насны хүүхдүүдийг учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “**Хүүхэд ба эрсдэл**” цуврал нэвтрүүлэгийн 3 дугаар бэлтгэн иргэд, олон нийтэд хүргэн ажиллаж байна. Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Малын хулгайн гэмт хэргээс хамтдаа урьдчилан сэргийлье” шторкыг бэлтгэн иргэдэд хүргэсэн. Телевизээр: Цагдаагийн газраас 2017 оны 03 дугаар улиралд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 178 удаа, 3 цаг, 54 минутын хугацаатай нэвтрүүлэг, ярилцлага, сэрэмжлүүлэг, мэдээ, мэдээллийг орон нутгийн “Арвайхээр чөлөөт суваг”, “Дөлгөөн-Соёмбо”, “Хас”, “GM”, улсын чанартай ТВ-9 инфо”, “Молор” телевизүүдээр явуулж, 232 удаагийн давталттайгаар иргэд олон нийтэд хүргэсэн. Радиоогоор: Ноён-Уул FM 102.6 радио, Авто радио FM -93.68 зэрэг радио FM-ээр нийт 38 удаа, 1 цаг 15 минутын хугацаатай ухуулга, сурталчилгааг 42 удаагийн давтамжтайгаар нэвтрүүлсэн. Цахим хуудсаар: Нийт 104 мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэгийг цагдаагийн газрын пэйж хуудас, вэйб сайт, www.police.gov.mn, www.tsagdaa.ukh.@gmail.com цахим хуудас болон олон нийтийн сүлжээ хуудсуудад байршуулсаныг давхардсан тоогоор 11798 гаруй иргэд, олон нийтэд хүргэсэн. “Өвөрхангайн элч”, “Өвөрхангайн өнгө”, зэрэг сонин, сэтгүүлд 29 мэдээ, мэдээлэл, ярилцлага, нийтэлсэн.

Цахим программ хангамж бүхий нээлттэй үйлчилгээг нэвтрүүлж, олон нийттэй харилцах ахлах байцаагчид хариуцуулсан ба иргэдээс байгууллага, албан хаагчдад хандаж тавьсан хүсэлт, саналыг хүлээн авсан ажилтан өөрөө хариуцан бусад төрийн байгууллага, ажилтантай цахим шуудангаар хууль тогтоомжийн дагуу харилцаж хариу авч, хүсэлт гаргасан иргэнд хариуг өгч байна. Байгууллагын “Цахим сан”-д тогтмол мэдээлэл оруулах, ажлын хэсгийг томилж, иргэд олон нийтэд мэдээллийг хүргэж байна. Цагдаагийн газрын үйл ажиллагааг

сурталчилах, иргэдэд нээлттэй ил тод, шуурхай хүртээмжтэй ажил үйлчилгээг үзүүлэх зорилгоор uvurkhangai.police.gov.mn вэб сайтыг ажиллуулж, 2017 оны эхний 10 сард веб сайтад 75, цагдаагийн газрын page хуудсанд 56 мэдээллийг боловсруулан тавьж, иргэдэд сурталчилсан байна. Цагдаагийн газрын даргын шийдвэрээр байгууллагын томилгоот бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж “Сурвалжлагч алба хаагч” томилон цагдаагийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг фото зургаар бэхжүүлэн танилцуулгыг байгууллагын хаалттай группэд тавьж нийт бүрэлдэхүүнд мэдээлэх ажлыг хэвшүүлж эхлээд байна. 2017 оны 09 дүгээр сард аймгийн хуулийн байгууллагууд оролцсон “Нээлттэй хаалга”-ны өдөрт оролцож иргэд олон нийтэд байгууллагаас хийж гүйцэтгэж буй ажил арга хэмжээ, шинээр батлагдсан хууль тогтоомжийг сурталчилж иргэнээс санал асуулгын хуудсаар санал хүсэлтийг хүлээн авч иргэнд хариу өгөв. Шинээр томилогдсон “Иргэний зөвлөл”-ийн гишүүдийг газрын удирдлага хүлээн авч, санал солилцов. Архидалтгүй Өвөрхангай хөтөлбөрийн хүрээнд Аймгийн Засаг даргын А/479 дүгээр захирамж гарч аймгийн хэмжээнд байгууллага бүрээс төлөөлөл гарч согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох явдалтай тэмцэх чиглэлээр цагдаагийн ажилтнуудтай хамтарсан эргүүл хийж эхлээд байгаа ба аймгийн төвд гудамж талбайд үйлдэгдэж буй гэмт хэргийг бууруулах чиглэлээр “Хөдөлгөөнт эргүүл”-ийг 3 автомашинтайгаар 10 дугаар сараас эхлэн ажиллуулж байна. 09 дүгээр сарын 29- өөс 10 дугаар сарын 01-ний өдрүүдэд ЦЕГ-ын Сүлд чуулгын уран бүтээлчидтэй хамтран “Үргэлж тантай хамт” өдөрлөгийг Арвайхээр хотод зохион байгуулж БОЭТ, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Ерөнхий боловсролын сургуулиуд, “Хангамж худалдааны төв” дээр урлагийн тоглолт үзүүлж цагдаагийн байгууллагыг сурталчилж, алба хаагчдыг алдаршуулсан ба аймгийн Хөгжимт жүжгийн театрт болсон “Сүлд” чуулгын уран бүтээлчдийн тоглолтыг 400 гаруй иргэд үзэж сонирхов.

Дөрөв. “Эрх зүйн сургалт сурталчилгааны төлөвлөгөөний хүрээнд хийсэн ажил арга хэмжээ

Хууль сахиулахын их сургуулийн эчнээ дамжаанд 6 алба хаагч, Хууль сахиулахын их сургуулийн магистрийн ангид 2 алба хаагч, нохойн төлөөлөгчийн сургалтанд 1 алба хаагч тус тус хамрагдсан. Энэ 09 дүгээр сард зохион байгуулсан төрийн тусгай албан тушаалын сул орон тооны сонгон шалгаруулалтанд 10 иргэний материалыг хүргүүлж 5 иргэн тэнцэж Хууль сахиулахын их сургуулийн Ахлагчийн дамжаанд суралцаж байна. Мөн хөтөлбөрийн хүрээнд хууль сахиулахын их сургуулийн ахлагчийн сургууль төгссөн 2 сонсогчийг ахлагч албан тушаалд томилсон ба Замын цагдаагийн тасгийн дарга, дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга нарын ажлын байр өөрчлөгдөж шинээр томлогдсон алба хаагч нарын ажлыг хүлээлцүүлэв.

ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн албанаас зохион байгуулж буй Өвөрхангай, Баянхонгор Архангай аймгийн эрүүгийн цагдаагийн алба хаагч нарыг хамруулсан “Бүсчилсэн сургалт”-ыг 09 дүгээр сарын 25-аас 10 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулж танилцуулгыг ЦЕГ-ын даргын нэр дээр хүргүүлэв. Тус аймгаас 2017 оныг “Ахмадыг дээдлэх жил” болгон зарласантай холбогдуулан ЦЕГ-ын Ахмадын хороотой хамтран тус цагдаагийн газраас төрөн гарсан Монгол улсын гавьяат цолтон төв орон нутгийн газар хэлтсийн даргаар ажиллаж байгаад цэргийн байнгын тэтгэвэрт гарсан хурандаа цолтнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ болон байгууллагын ахмадын баярыг 09 дүгээр сарын 20-оос 24-ний өдрүүдэд зохион байгуулж дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Тус цагдаагийн газраас төрөн гарсан Монгол улсын гавьяат цолтон төв орон нутгийн

газар хэлтсийн даргаар ажиллаж байгаад цэргийн байнгын тэтгэвэрт гарсан хурандаа цолтнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ болон байгууллагын ахмадын баярыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсэг томилсон тушаал гаргаж, аймгийн Засаг даргад төлөвлөгөө удирдамжийн хамт хүргүүлж тодорхой хэмжээний хөрөнгийг шийдвэрлүүлэв.

2. 2017 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр Арвайхээр хотын “Хүндэтгэлийн хаалга”-н дээр цагдаагийн газрын зөвлөлийн гишүүд гавьяат цолтон, болон ахмад хурандаа нарыг тосон авч хүндэтгэл үзүүлсэн ба цагдаагийн газрын “Сургалтын төв”-ийн гадна талбайд газрын дарга цагдаагийн хурандаа О. Ганбат хүлээн авч байрлуулан үдийн хоол идүүлж ажлын явц, аймаг орон нутгийн нөхцөл байдлын талаар танилцуулав. Энэ өдөр аймгийн Засаг дарга, ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга нар хүндэт зочдыг аймгийн “Хүндэтгэлийн танхим”-д хүлээн авч Монгол улсын гавьяат хуульч цагдаагийн бэлтгэл хурандаа П. Лувсандорж, Монгол улсын үйлчилгээний гавьяат ажилтан цагдаагийн бэлтгэл хошууч Ё. Ядамсүрэн нарыг Монгол улсын Ерөнхий сайд сайн ноён хан Т. Намнансүрэнгийн нэрэмжит “Төрийн шилдэг түшээ” цол тэмдэг мөнгөн шагнал, цагдаагийн бэлтгэл хурандаа Л.Билгээг аймгийн Засаг даргын “Хүндэт өргөмжлөл” мөнгөн шагнал, Арвайхээрийн 290 жилийн ойн хүндэт тэмдэг, цагдаагийн бэлтгэл хурандаа Х. Рэгсүрэнг “Аймгийн алдартан” тэмдэг, цагдаагийн бэлтгэл хурандаа Б. Бэхбатыг Ерөнхий сайд П. Гэндэнгийн нэрэмжит “Хүндэт тэмдэг мөнгөн шагнал”-аар тус тус шагнав. Мөн цагдаагийн бэлтгэл хурандаа Ц. Даваадорж, Ц. Ичинноров, Ч. Баточир, Б. Батбаяр нарыг аймгийн ИТХ-ын “Хүндэт жуух бичиг”, Арвайхээр сум байгуулагдсаны 290 жилийн ойн “Хүндэт тэмдэг” бэлэг дурсгалын зүйлээр шагнаж урамшуулав. Энэ орой “Алтан холбоо” зоогийн газар аймгийн удирдлага цагдаагийн газрын зөвлөлийн гишүүд зочдыг хүлээн авч хүндэтгэлийн зоог барьж, урлагийн тоглолт үзүүлж, “Сургалтын төв”-ийн амралтын байранд байрлуулж амраав.

Өдөр 11.40 цагаас Аюуш баатарын талбайд аймгийн Засаг дарга, ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга, хуулийн байгууллагуудын удирдлага, байгууллагын ахмад настнууд хүндэт зочдын хамт Аюуш баатарын хөшөөнд цэцэг өргөсөн бөгөөд аймгийн “Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагууд”-ын бие бүрэлдэхүүн ёслолын жагсаал хийж хүндэтгэл үзүүлэв. Энэ үеэр Монгол улсын гавьяат хуульч цагдаагийн бэлтгэл хурандаа П.Лувсандорж цагдаагийн бэлтгэл хурандаа Ч. Баточир нарыг ЦЕГ-ын шагнал “Цагдаагийн төлөө” тэмдэг, Монгол улсын үйлчилгээний гавьяат ажилтан цагдаагийн бэлтгэл хошууч Ё. Ядамсүрэнг ЦЕГ-ын шагнал “Цагдаагийн гавьяа” тэмдэгээр шагнасныг Аймгийн Засаг дарга, Цагдаагийн газрын дарга нар гардуулж өгөв. Өдөр 14 цагаас нийт алба хаагч нартай хүндэт зочид уулзалт хийж, шинэ залуу алба хаагч нарт үнэтэй зөвлөгөө өгч дурсгалын зураг татуулсан бөгөөд цагдаагийн газрын алба хаагчдын бэлтгэсэн хүндэтгэлийн концертыг үзэж сонирхов. Орой 19 цагаас “Сургалтын төв”-д хүндэт зочдод цагдаагийн газраас хүндэтгэл үзүүлж хүлээн авалтын арга хэмжээ зохион байгуулав.

4. 09 дүгээр сарын 22-ны өдөр хүндэт зочдыг аймгийн орон нутгийг судлах музей үзүүлж уг музейд “Алдарын булан” байгуулах талаар тохиролцсон ба “Арвайхээр хотын хүндэтгэлийн өндөрлөг” дээр гарч хотын ерөнхий байдлыг сонирхуулж, дараа нь аймгийн төвөөс баруун тийш орших “Монгол түмний морины их шүтээн цогцолбор”-ыг үзүүлж Авзага хайрхан ууланд хүндэтгэл үзүүлэв. Цагдаагийн газрын үйл ажиллагаатай танилцсаны дараа өдөр 12 цагаас Сургалтын төв”-д цагдаагийн газрын ахмад настнуудыг оролцуулсан өдөрлөгийн ажиллагаанд зориулсан хүчит 32 бөхийн барилдаан болж Сант сумын хэсгийн төлөөлөгч цагдаагийн ахлах дэслэгч, сумын заан Ц. Бээжин түрүүлж, мэдээлэл хүлээн авагч цагдаа цагдаагийн дэд ахлагч сумын заан Ц. Батзориг үзүүрлэж шагналыг хүндэт зочид гардуулав. Энэ үеэр байгууллагын

ахмад настнууд үе үеийн удирдлагуудтайгаа уулзсан ба ахмадын хурлаа хийж зөвлөлийн гишүүд даргаа сонгож баталгаажуулав. ЦЕГ-ын Ахмадын хорооны шагнал “Гавьяат үйлстэн” тэмдэгийг нэр бүхий 12 ахмад настанд Монгол улсын гавьяат хуульч цагдаагийн бэлтгэл хурандаа П.Лувсандорж, ЦЕГ-ын ахмадын хорооны тэргүүн бэлтгэл цагдаагийн хурандаа Л.Билгээ нар гардуулан өгч баяр хүргэв. 09 дүгээр сарын 23-ны өдөр хүндэт зочдыг Улаанбаатар хотын зүг үдэж мордуулсан ба эдгээр арга хэмжээг аймгийн “Арвайхээр” телевизээр иргэд олон нийтэд сурталчлав.

5. Ахмадын баярыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд 09 дүгээр сарын 30-ны өдөр ЦЕГ-ын “Сүлд” чуулгын уран бүтээлчидтэй хамтран байгууллагын ахмад настан цагдаагийн бэлтгэл ахлах ахлагч С.Цэндаюушийн гэрт очиж хүндэтгэл үзүүлэн бэлэг дурсгалын зүйл гардуулж урлагийн хэсэгчилсэн тоглолт үзүүлж сонирхуулав. Тус аймгаас 09 дүгээр сарын 07-10 ны өдрүүдэд зохион байгуулсан “Ахмад мастеруудын улсын аварга” шалгаруулах тэмцээнд оролцохоор ирсэн “Хилчин спорт хороо”-ны 43 ахмад тамирчныг 2 өдөр хоол байраар хангаж, үйлчилсэн зэрэг арга хэмжээг зохион байгуулсан байна.

Тав. Цаашид хэрэгжүүлэх ажлын талаар.

Түдгэлзүүлсэн хэргийн нөхөн илрүүлэлтийн хувийг ахиулах зорилгоор “Сэргээн шийдвэрлэлт”, “Илрүүлэлт оргодол” нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг эрчимжүүлж, үр дүнг тооцох

Алба хаагчдын сахилга, хариуцлагыг сайжруулах зорилгоор удирдах болон ахлах ажилтнуудын шат дараалсан хяналтыг сайжруулж, манлайллыг дээшлүүлэх

“Аюулгүй иргэн-Амартайван Өвөрхангай” уриан доор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Бодлогын баримт бичиг” боловсруулах ажлын хүрээнд иргэд олон нийтийн дунд санал авах “Харилцах дэвтэр” аялуулан гарсан саналыг нэгтгэн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж хэрэгжилтийг ханган ажиллах

“Архидалтгүй-Өвөрхангай” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулж буй ажлыг эрчимжүүлж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох явдлыг таслан зогсоох талаар гарсан аймгийн Засаг даргын 2017 оны А/479 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх, “Орон нутгийн замын хөдөлгөөний соёл” аяны хүрээнд зохион байгуулж буй “Хамгаалах малгай” нэгдсэн арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэн, үр дүнг тооцох

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ТАСГИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

Д.ЭРДЭНЭБАТ

ХЯНАСАН: ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.ГАНБАТ

